

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН
ХЭЛТСИЙН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв сая/төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилгот түвшин /эхний хагас жил/	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙГ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХҮРЭЭНД:							
1.1	НЗДҮАХ –ийн 3.4.1. Жуулчдыг татах ачлал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна.						
1.1.1	3.4.1. Гандангийн дэнж шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг зөвшилцөх	7,000.0	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	НИТХТ-ийн 2015 оны 98 дугаар тогтоол	100	Соёлын яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу “Гандангийн дэнж” шинэ аялал жуулчлалын бүсийн зураг төсөв, барилгын ажил /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо/ төслийн дагуу ажлын даалгаварын инженерийн дэд бүтцийн хэсэгт санал өгч Ерөнхий архитекторын ажлын албанд хүргүүлсэн. ТЭЗҮ боловсруулагдаж ирүүлээгүй байна. Барилга хот байгуулалтын яамны захиалгаар гүйцэтгэж байгаа Баягол дүүрэг 16 хороо Гандангийн дэнж инженерийн шугам сүлжээний ажил” төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээний “Кингс энд Инженеринг” ХХК-ний гүйцэтгэсэн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан.	100
2	НЗДҮАХ –ийн 6.1.1, НХТЖҮЧ-ийн 9.1.1, НХЖТ-ний 6.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж үе шаттай хэрэгжүүлнэ.						

2.1.1	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний инженерийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөгөөг зөвшилцөн санал хүргүүлэх	338.2	УИХ-аар батлагдсан баримт бичгийн тоо	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал концепци батлагдсан	70	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860, А/1201 дугаар захирамжаар “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэсэн “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-нд Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 239 дүгээр тушаалаар томилогдсон мэргэжлийн чиглэлийн экспертүүдийн гаргасан хавсралт дүгнэлтийн дагуу Барилгын хөгжлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 2025/2021 дугаар магадлалын нэгтгэсэн дүгнэлт бүхий баримт бичгийг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 01/14 дүгээр албан бичгээр ирүүлсэн төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд оруулах саналыг нэгтгэн Ерөнхий архитекторын ажлын албанд өгсөн. Одоогийн байдлаар гүйцэтгэгч Хот төлөвлөлт судалгааны институт ОНӨААТҮГ-аас хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нэгтгэж ирүүлээгүй байна.	100
2.1.2	2.1.3.Нийслэлийн ногоон бүс /зуслан/-ийн 22 амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний суурь судалгаа, төлөвлөлтийн шийдлийг хянан зөвшилцөх.	-	Боловсруулсан ХЕТ-ний тоо	5 ХЕТ	40	Улаанбаатар хотын Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр дэх “Зуслангийн 4 амны ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажил”-ыг гүйцэтгэгч Ланд овнер” ХХК-ийн эхлэлийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн 03 дугаар сарын 15-ны өдрийн 5 дугаар хурлаар хэлэлцүүлж хүлээн авсан. Тус эхлэлийн тайланд инженерийн хангамжийн одоогийн байдлын судалгаанд нэмэлтээр хийгдэх шаардлагатай гүний худаг ашиглалтын байдал, нүхэн жорлонгийн судалгаа, цахилгаан хангамжийн судалгааг авахад дэмжлэг үзүүлэх талаар Нийслэлийн Байгаль орчны газар, УБЦТС ТӨХК, УСУГ ОНӨААТҮГ-уудад албан бичиг хүргүүлж шаардлагатай мэдээллийг зөвлөх үйлчилгээний компанид хүргүүлсэн.	100

2.1.3	2.1.4.Сонсголон, Амгалан, Шинэ төв дэд төвийн ТЭЗҮ, ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянан зөвшилцөх.	425.0	НИТХ-аар батлуулах баримт бичгийн тоо	-	3 баримт бичиг боловсруулсан байна.	<p>“Амгалан”, “Шинэ төв”, “Сонсголон” дэд төвүүдийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төслийг “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-аас боловсруулан эхлэлийн болон дундын тайланд инженерийн дэд бүтцийн чиглэлээр тусгагдсан ажилтай танилцан санал тусгуулан Мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 05 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан. Одоогийн байдлаар төлөвлөлтийн шийдэлд санал тусгуулахаар өгч ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, мэдээлэл холбоо сүлжээний худаг сувагчлалын төлөвлөлтийн шийдэл зөвшилцсөн, дулаан хангамжийн төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх шатандаа явж байна.</p>	80
2.1.4	2.1.5.Нисэх, Тахилт Дарь эх, Монель, Бичил, Ургах наран Хайлааст олон нийтийн төвүүдийн ТЭЗҮ, барилгажилтын төслийн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянан зөвшилцөх.	619.7	НИТХ-аар батлуулах баримт бичгийн тоо	-	7 баримт бичиг боловсруулсан байна.	<p>“Нисэх олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-аас боловсруулсан төслийн инженерийн хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлтийн шийдэлд санал тусгуулан эцсийн тайланг зөвшилцсөн.</p> <p>“Дарь-Эх олон нийтийн төв”, Монел олон нийтийн төв” Тахилт олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч “Зураг төсөл консалтинг” ХХК-ийн боловсруулсан төслийн инженерийн хангамжийн одоогийн байдлын судалгаа, төлөвлөлтийн шийдэлд санал тусгуулан эцсийн тайланг зөвшилцсөн.</p> <p>“Бичил олон нийтийн төв”, “Ургах наран олон нийтийн төв”, Хайлааст олон нийтийн төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл боловсруулах ажлын гүйцэтгэгч “Арткон” ХХК-ийн боловсруулсан төслийн инженерийн хангамжийн одоогийн</p>	90

						байдлын судалгаа, төлөвлөлтийн шийдэлд санал тусгуулан эцсийн тайланг зөвшилцсөн.	
2.2	2. НЗДҮАХ-ийн 6.1.2. НХТЖҮЧ-ийн 9.2.1 . Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөрлийг бууруулна.						
2.2.1	Яармаг хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөөг /Нисэх Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний инженерийн дэд бүтцийн суурь судалгаа, төлөвлөлтийн шийдлийг хянан зөвшилцөх.	-	Шинэчлэн боловсруулсан ХЕТ-ний тоо	НИТХТ-ийн 2015 оны 198 дугаар тогтоол	1	Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/651 дүгээр захирамжийг үндэслэн нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Сонголт дизайн” ХХК-тай байгуулсан гэрээгээр гүйцэтгэж буй Улаанбаатар хотын төлөвлөлтийн “27 дугаар нэгж хороолол”-ын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний эхлэлийн тайланд санал тусгуулан хүлээн авсан	50
2.3	2.4.НЗДҮАХ –ийн 6.1.9, НХТЖҮЧ-ийн 9.8, Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, нийтийн зориулалттай орон сууцыг засварлан иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангана.						
2.3.1	2.4.1.Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийн даалгаврыг боловсруулан баталж, ажлын зураг төсөлд хяналт тавьж, хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх .	14,876.5 Улс, нийслэл	Ажлын зураг төсөл зөвшилцсөн тоо	18 багц байршилд гадна инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний угсралт хийгдсэн.	4	Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг 1 байршилд зөвшилцсөн Хэрэгжүүлж буй төслүүдийн явцтай уялдуулан 2022 оны төсвийн тодотголд тусгуулахаар 17 багцын 29,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг 2023 оны төсөвт тусгуулахаар 6 багцын 24,1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг ХБТХ-т хүргүүлсэн. Одоогийн байдлаар 15 багцын төсөлд 27,4 тэрбум төгрөгийг улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж 4979 айлын орон сууц төлөвлөснөөс 3036 айлын орон сууц ашиглалтад орсон байна.	100
2.3.2	2.4.2. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгын судалгаа, загвар зураг төслийн ажлын даалгаварт санал хүргүүлэх, гадна инженерийн	-	Боловсруулсан судалгааны тоо	2040 оны суурь судалгаа	1	Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслийн гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл 2 байршилд зөвшилцсөн.	100

	шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх.						
2.4	2.6.НЗДҮАХ-ийн 6.1.8 НХТЖҮЧ-ийн 9.7.1, 9.7.2, 9.7.3 Түрээсийн олон төрөлт болон оршин суугчдын орлогод нийцсэн ногоон орон сууцны шинэ хорооллуудын бүтээн байгуулалтыг эрчимжүүлнэ.						
2.4.1	2.6.1 “Залуус-1” орон сууцны хорооллын төслийн гадна инженерийн 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, барилга байгууламж, авто замын ажлыг эхлүүлэх	-	Инженерийн шугам сүлжээний зураг төсөл зөвшилцсөн байдал	Инженерийн шугам сүлжээний зураг төслийн ажил боловсруулж эхэлсэн.	100	Барилга, хот байгуулалтын яамны захиалагаар хэрэгжиж буй Залуус-1 орон сууцны нэгж хороолол нь 57.0 га нэгж талбайд 5616 айл өрхийн 24 398 хүн амтай төлөвлөгдсөн Тус төслийн эхний ээлжийн барилга байгууламж нь 13 дугаар магистраль, төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээнээс тэжээгдэхээр 7.5 Гкал/цаг-ийн техникийн нөхцөл олгогдсоны дагуу 1 дүгээр хэлхээний шугам сүлжээ, 80 Гкал/цаг-ийн хүчин чадалтай дулааны эх үүсвэрээс хангагдах дулаан хуваарилах төв, төвлөрсөн дулааны сүлжээтэй хосломол ажиллагаатай ажиллах гадна дулааны шугам сүлжээний ажлын зураг төсөл, цахилгаан хангамжийн 110/35/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын ЦДАШ-ын трасс, 10 кВ-ын кабель шугам, хуваарилах байгууламж, хаалттай дэд өртөөний барилгын зураг төсөл, 2х1000м3 усан сан, ус хангамж, ариутгах татуурга, гадна дулааны шугам, инженерийн бэлтгэл арга хэмжээ, холбоо мэдээллийн худаг сувагчлалын ажлын зураг төсөл зөвшилцсөн. 2022 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эхний ээлжийн барилгажилтын төслийг хангах шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажил эхэлсэн.	100
3	Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж ыүс орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.						
3.1	ЗГҮАХ-ийн 3.7.4, НЗДҮАХ-ийн 6.2.1. Дагуул хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулна.						
3.1.1	6.2.1.4. Богдхан уулыг тойрсон "Хөгжлийн алтан тойрог" байгуулах, ТЭЗҮ-ажлын даалгаварт санал хүргүүлэх.	-	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл	1	Богдхан уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” байгуулах техник эдин засгийн үндэслэлийн урьдчилсан трассын дагуу дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний судалгаа боловсруулан танилцуулга бэлтгэн Ерөнхий архитекторын ажлын албанд хүргүүлсэн.	-

						Үнэлэх боломжгүй.	
3.1.2	6.2.4. Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаварт санал хүргүүлэх, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх	-	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал	1	Шинэ дагуул хотуудыг түшиглэн барих дулаан цахилгааны 5 дахь эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах даалгаварт 2021 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 06/946 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн. Тус төслийн дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх үйлчилгээг Мон-Энержи ХХК боловсруулж байна. Дундын тайланг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэхэд холбогдох саналыг хүргүүлсэн. .	70
3.1.3	6.2.7. Ачаа тээврийн логистик төв байгуулах техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх.	-	Ажлын даалгаврын тоо	УБ хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал	1	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Үнэлэх боломжгүй.	
3.1.4	6.2.1.6. “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл зөвшилцөх		ТЭЗҮ, ХЕТ тоо	2		Хөрөнгө шийдвэрлэгдээгүй. Үнэлэх боломжгүй.	
4	6.3.Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.						
4.1	НЗДҮАХ-ийн 6.3.21. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.						
4.1.1	НЗДҮАХ-ийн 6.3.21. Голуудын эрэг болон үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн шинэчилнэ.	-	Ажлын зураг зөвшилцсөн байдал	-	100	Хан-уул дүүргийн 8, 21 дүгээр хороо, Жаргалантын амны үерийн хамгаалалтын байгууламжийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаварыг 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 03 дугаар хурлын шийдвэрээр хэлэлцүүлэн баталуулсан. МЗХ2022/03-01	100

						дугаартай мэргэжлийн зөвлөлийн даалгаврыг ГУББГ ОНӨААТҮГ, нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т хүргүүлсэн. Тус ажлын хүрээнд нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/281 тоот захирамжаар зураг төсөл, барилга угсралтын ажлын 3,6 тэрбум төгрөгийн хөрөнгө шийдвэрлэгдэн худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалт хийгдсэн.	
4.2	НЗДҮАХ-ийн 6.3.24. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барина.						
4.2.1	6.3.6."Буянт-Ухаа 2" хороолол орчимд барих усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.		Усан сан, цэвэр усны шугамын ажлын зураг төсөл боловсруулагдана.		Усан сан, шугам сүлжээний ажлын барилга угсралтын ажлыг эхлүүлсэн.	2022 оны төсвийн тодотголд тусгуулан шийдвэрлүүлэхээр Нийслэлийн засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, ЗАА-нд 2022 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 08/1803 дугаартай албан бичгээр хүргүүлсэн	30
4.2.2	6.3.7.Толгойт, их наран орчимд барих усан сан, шугам сүлжээний барилга, угсралтын ажлыг эхлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Ажлын зураг төсөл батлагдсан.		Толгойт, Их наран орчимд барих усан сан, шугам сүлжээний барилга, угсралтын ажлыг эхлүүлэх ажлын хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 4 хороо Их нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф400мм-ийн голчтой 2,8 км шугамын ажил хийгдэж дууссан. Тус ажлын хүрээнд 2х500 м3 усан сангийн барилгажилтын ажил, цэвэр усны цагираг шугам сүлжээний ф150/ф250 мм-ийн 7.8км шугамын ажил хийгдсэн бөгөөд цэвэр усны шугамын ажлын зураг төслийг "Хайдродизайн инноваци" ХХК боловсруулан баталгаажуулсан.	100
4.2.3	6.3.11."Буянт-Ухаа 2" хороолол орчмын ариутгах татуургын гол шугамын 2 дугаар ээлжийн ажлыг үргэлжлүүлэх	500.0 Улсын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Ажлын зураг төсөл батлагдсан.		Буянт ухаа -2 хорооллын II дугаар ээлжийн барилгажилтын төслийн ариутгах татуургын шугамын 3 дугаар хэсгийн шугамын трассыг Солонго хорооллын барилгажилтын төсөлтэй уялдуулах ажлын зургийн өөрчлөлтийг Түвшинжин ХХК гүйцэтгэж байна.	100

4.2.4	6.3.12. Дарь эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлыг эхлүүлэх	2,000.0 Улсын төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Ажлын зураг төсөл батлагдсан		Дарь эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын барилга угсралтын ажлын санхүүжилт хэсэгчилэн шийдвэрлэгдсэн бөгөөд барилга угсралтын ажил эхлээгүй байна. Тус ажлын хүрээнд ф300мм-ийн хүчин чадалтай 4.8км ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөл зөвшилцөн, трассыг мэдээллийн санд оруулсан.	100
4.2.5	6.3.13.Зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлын зураг төслийг боловсруулах	500.0 Улсын төсөв	Ажлын зураг зөвшилцөн тоо	-	1 багц ажлын зураг төсөл батлагдсан байна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй “Зөөврийн усан сан Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг” нэртэй төслийн хүрээнд зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбох Сонгинохайрхан дүүргийн 24, 25 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 5 байршлын ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг мэргэжлийн зөвлөлийн хуралаар хэлэлцүүлэхээр хурлын жагсаалтанд оруулсан.	50
4.2.6	6.3.18. Чингэлтэй дүүргийн Сервис центрийн бохирын цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрөм байгуулна.	1,000.0 Улсын төсөв	Ажлын зураг зөвшилцөн тоо	-	1	2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 01 дүгээр хурлын шийдвэрээр Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо, Сервис центрийн бохирын цэвэрлэх байгууламжаас гарах саарал усыг цуглуулах цөөрмийн ажлын зураг төсөл боловсруулах даалгавар батлуулан Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.	100
4.2.7	6.3.19. Шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам, дэд станц барьж цахилгаан хангамжийг сайжруулна.	11,816.8 Улсын төсөв	Ажлын зураг зөвшилцөн тоо	1233, дэд өртөө	4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах, шугам дэд станц барьж, шугам сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулах 101 байршлын ажлын зураг төслийг зөвшилцсөн.	100
4.2.8	6.3.22. Сэлбэ дэд төвийн дулааны эх үүсвэрийг ашиглалтад оруулж, Дамбадаржаа, Дэнжийн 1000 дэд төвүүдийн дулааны эх үүсвэрийн ажлын зураг төслийг бүрэн дуусгана.	-	Ажлын зураг зөвшилцөн тоо	Сэлбэ дулааны станцын ашиглалтын туршилт, тохируулгын ажил	2	Сэлбэ дэд төвийн дулааны эх үүсвэр нь 2022 онд ажиллагаанд залгагдсан бөгөөд тус дулааны эх үүсвэрээс 29 аж ахуйн нэгж, байгууллага төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбогдсон. Сэлбэ дэд төвийн дэд бүтэц, гадна инженерийн шугам сүлжээний бүтээн байгуулалт нь 99,3%-ийн гүйцэтгэлтэй байна.	100

				хийж байна.		<p>Дамбадаржаа дэд төвийн 63 МВт хатуу түлшний дулааны эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэл нь Эрчим хүчний яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар хурлын 06 дугаар тэмдэглэлээр батлагдсан. Ажлын зураг төсөл зөвшилцөж, магадлал хийгдсэн. Газар чөлөөлөлтийн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй байна. Шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр 76 тэрбум төгрөг шийдвэрлэгдээгүй байна. Дамбадаржаа дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцсөн.</p> <p>Дэнжийн 1000 дэд төвийн 80Гкал/цаг-ийн хий хангамжийн эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл батлагдсан. Эх үүсвэрийн барилга угсралтын ажилд шаардлагатай 10 сая долларын гэрээ АХБ-ны төслөөр хэрэгжүүлэхээр батлагдсан.</p>	
4.2.9	6.3.23. Улаанбаатар хотын дулаан хангамжийн 11 г, д ф800мм-ийн гол шугамыг ф1000 мм голчтой болгон өргөтгөх зураг төсөв, барилга угсралтын /1 дүгээр хорооллын урд талаас баруун 4 замын уулзвар хүртэл, павильон 19-өөс 3/11 холбоос хүртэл 3,4 км/ Сонгинохайрхан дүүрэг ажлыг үргэлжлүүлнэ.	2,000.0 Улсын төсөв	Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км	3,4км	ф800мм-ийг ф1000 мм голчтой болгон өргөтгөнө	Улсын төсвин хөрөнгөөр хийгдэх 11г,д ф800мм-ийн гол шугамыг ф1000мм голчтой болгон өргөтгөх 0,716 хос.км дулааны шугамын ажлын зураг төслийг 2022 оны нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан. Дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр 2022 оны нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.	100
4.2.10	6.3.24. Дулааны цахилгаан станц 4-өөс у-18 хүртэлх/ Москва хорооллын урд тал хүртэл/ 4,2 км, ф800-ийн голчтой дулааны шугамын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	1,800.0 Улсын төсөв	Ажлын зураг зөвшилцсөн шугамын урт, км	-	4,2 км	Дулааны цахилгаан станц 4-өөс у-18 хүртэлх/ Москва хорооллын урд тал хүртэл/ 4,2 км, ф800-ийн голчтой дулааны шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Тус шугамын бүтээн байгуулалтын ажил 64%-тай хийгдэж байна. Дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр 2022 оны нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.	100

4.2.1 1	6.3.25. 2а, 4а, 4б, 10в, 10г, 10д магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх	16,170.0 Гадаад ын зээл туслам ж	Ажлын зураг зөвшилц өн шугамын урт, км	7,55 км шугам	2,7 км дулааны шугамын угсралты н ажил хэрэгжүү лсэн байна.	- 4а магистраль ДХ408-р цэгээс ДХ-435-р цэг хүртэлх 2ф250/350мм голчтой 1.1 хос.км шугамыг 2ф700мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх ажлын 6,9 тэрбум.төгрөг Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөгдсөн. - 10в,г,д магистраль шугамын ажлын зураг төслийг БХБЯамны санхүүжилтээр Эрчим төсөл ХХК гүйцэтгэсэн бөгөөд манай байгууллагатай урьдчилсан байдлаар гүйцэтгэсэн байна. - 4а, б, 2в, 10в,г,д магистраль шугамын дулааны шугамын трассын дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр 2022 оны нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.	100
4.2.1 2	6.3.26. БЗД-ийн 10 дугаар хороо, Төмөр замын 2-р анги Амгалан орчмыг хангах дулааны шугам шинээр татах	330.0 Гадаад ын зээл туслам ж	Ажлын зураг зөвшилц өн шугамын урт, км	-	2,2 хос км шинээр хийгдсэн байна.	Төвлөрсөн дулаан хангамжийн БЗД-ийн 10 дугаар хороо, Төмөр замын 2-р анги Амгалан орчмыг хангах дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр 2022 оны нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.	100
4.2.1 3	6.3.27.Шинээр 240 Гкал/ цаг-ийн дулааны ачаалал бүхий дахин төлөвлөлтийн бичил VI хорооллуудыг дулааны эрчим хүчээр хангах боломжийг бүрдүүлэх	2,200.0 Гадаад ын зээл туслам ж	Ажлын зураг зөвшилц өн шугамын урт, км	-	0,695 км	Төвлөрсөн дулаан хангамжийн VII хорооллуудыг дулааны эрчим хүчээр хангах 2ф400 хос.км дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Дулааны шугамын трасс дагуух газар олголтыг шийдвэрлүүлэхээр 2022 оны нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.	100
4.2.1 4	6.3.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлуулах.	-	Төлөвлөг өө 1	-	Инженер ийн бэлтгэл арга хэмжээни й төлөвлөг өө боловсру улж	Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулах ажлын дундын болон эцсийн тайланг хүлээн авч, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 19 дүгээр хурлаар дундын тайланг хэлэлцүүлэн тайланг хүлээн авсан. Мэргэжлийн хурлаас гарсан санал зөвлөмжийг эцсийн тайланд тусгуулах талаар БХБЯ, БХТ, Престиж инженеринг ХХК-уудад 2022	100

					батлуулсан байна.	оны 6 сарын 16 өдрийн 08/2307 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.	
ХОЁР . ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ХҮРЭЭНД:							
<i>Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд:</i>							
2.1	Газрын стратеги төлөвлөгөөний тухайн жилийн зорилтын хэрэгжилтийг тайлагнаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Газрын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд нийт 20 зорилтын 54 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөө батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлаас хөрөнгө шийдвэрлэгдээгүйгээс шалтгаалан хэрэгжих боломжгүй 4 төсөл арга хэмжээ байна. 50 төсөл арга хэмжээний гүйцэтгэл 96,9 хувьтай байна.	100
<i>Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хүрээнд</i>							
2.2	Нийслэлийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын даалгавар боловсруулах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Улсын, нийслэл, орон нутгийн сангийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах тухай хүсэлтийг холбогдох байгууллагуудаас хүлээн авч 24 асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн . Үүнд: ✓ Дулаан хангамжийн шугам сүлжээ - 6 ✓ Цахилгаан хангамжийн шугам сүлжээ -2 ✓ Ус хангамж ,ариутгах татуургын шугам -4 ✓ Харилцаа холбооны шугам сүлжээ -2 ✓ Инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглээр- 10	100
2.3	Нийслэлийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт болон төсөл хөтөлбөр, зээл тусламжаар хэрэгжүүлэх инженерийн дэд бүтцийн ажлын зураг төслийг хянах, зөвшилцөх, хэрэгжилтэд хяналт тавих;	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Улаанбаатар хотын 9 дүүргийн 605 байршилд дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцсөн. Үүнд: ✓ Дулаан хангамж 99 ✓ Усан хангамж ариутгах татуурга 67 ✓ Цахилгаан хангамж 330 ✓ Харилцаа холбоо 90 ✓ Инженерийн бэлтгэл арга хэмжээ 19	100

2.4	Хот дахин хөгжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн инженерийн хангамжийн төлөвлөлтийн шийдлийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын тооцоо боловсруулан, холбогдох газруудад санал өгч шийдвэрлүүлэх, зураг төслийн даалгавар боловсруулан гүйцэтгэлийг хянан зөвшилцөх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг буулган дахин барилгажуулах төслийн 15 төсөл арга хэмжээний гадна инженерийн шугам сүлжээнд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэн 3036 айлын орон сууцны барилга баригдсан. Гэр хорооллыг дахин барилгажуулах төслийн хүрээнд 3 байршилд ажлын зургийн даалгавар боловсруулсан Гэр хорооллын дахин барилгажуулах төслийн 3 байршилд төлөвлөлтийн шийдэл зөвшилцсөн. Гэр хорооллын дахин барилгажуулах төслийн 2 байршлын барилгажилтын төсөл батлагдаагүй бөгөөд гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэлд санал, зөвлөмж хүргүүлэн ажилласан.	100
НЗДҮАХ-ийн 6.3.24.2.Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулна.							
2.5	21.1 Шинээр баригдах ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төслийг хянан зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Шинээр баригдах ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төслийг хянан зөвшилцөх ажлын хүрээнд шинээр ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний 4 байршилд зургийн даалгавар боловсруулж, 67 байршилд ажлын зураг төсөл зөвшилцөж ажилласан.	100
2.6	Бохир усны Туул -1 коллекторын 3, 4 дүгээр хэсгийн зураг төслийн өөрчлөлтийг зөвшилцөх, 4 дүгээр ээлжийн 5.4 км шугамын барилга угсралтын ажилтай уялдуулан шугамын трассын дагуух зөвшөөрөлгүй барилга байгууламжид мэдэгдэл хүргүүлж шийдвэрлүүлэх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Бохир усны Туул -1 коллекторын 3, 4 дүгээр хэсгийн зураг төслийн өөрчлөлтийг зөвшилцөх, 4 дүгээр ээлжийн 5.4 км шугамын барилга угсралтын ажилтай уялдуулан шугамын трассын дагуух зөвшөөрөлгүй барилга байгууламжид мэдэгдэл хүргүүлж шийдвэрлүүлэх ажлын хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны сайдын тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 3.4 хэсгийн ажлын зурагт өөрчлөлт оруулах зураг төслийн өөрчлөлийн хөрөнгийг НЗД-ын 2022 оны 4 сарын 7-ний өдрийн А/474 захирамжаар шийдвэрлэж НХОГ-т гэрээ байгуулахаар эрхийг шилжүүлсэн.	50

НЗДҮАХ-ийн 6.3.25.3. Одоо байгаа ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчилнэ.							
2.7	Одоо байгаа ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлын зураг төслийг хянан зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний гадна шугамын ажлын зураг төсөл 69 байршлын ажлын зураг хүлээн авснаас 55 байршилд гэр хорооллын 12 байршилд зураг төслийг баталгаажуулж ажилласан. - Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 84 тоот тогтоолоор батлагдсан "Ус хангамж, ариутгах татуургын техникийн нөхцөл олгох журам" дагуу Ус сувгийн удирдах газрын цэвэр бохир усыг татан зайлуулах техникийн нөхцөлийн хуралд 12 удаа оролцож санал өгч ажиллаж байна.	100
2.8	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчлийг арилгах талаар санал, дүгнэлтийг нэгтгэн, хууль эрх зүйн баримт бичиг нийцүүлэх санал оруулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Эрчим хүчний шугам сүлжээний хамгаалалтын зурвасын зөрчлийг арилгах ажлын хэсгийн бүрэлдхүүнд ажиллаж байгаа бөгөөд УБЦТС ТӨХК-ийн шугам тоноглолыг мэдээллийн сантай тулгалт хийж байна. УБДС ТӨХК-аас ирүүлсэн. дулааны магистрал шугамын хамгаалалтын зурваст барилга барьсан 44 байршлын судалгааг нарийвчлан зөвшөөрөлтэй болон зөвшөөрөлгүй барьсан барилгын мэдээлийг нэгтгэх ажлын хэсэгт танилцуулсан байна.	100
2.9	Баянзүрх дүүргийн 13, 14, 26 дугаар хороо "Туул" дэд станц, "Дүнжингарав" дэд станцаас Дэчинравжайлан хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар боловсруулах	-	Ажлын даалгаврын тоо	-	100	Баянзүрх дүүргийн 13, 14, 26 дугаар хороо "Туул" дэд станц, "Дүнжингарав" дэд станцаас Дэчинравжайлан хийдийн урд тал хүртэл цахилгаан хангамжийн шугам сүлжээний нэвтрэх сувгийн ажлын зураг төсөл боловсруулах даалгаварыг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн Мэргэжлийн зөвлөлийн 11 дүгээр хурлаар хэлэлцэн баталсан.	100
2.10	2022 он улс нийслэлийн төсөвт цахилгаан хангамжийн чиглэлээр тусгагдсан ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төслийг хянан зөвшилцөх	-	Ажлын зураг зөвшилцөн тоо	-	1	Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд 29,9 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэх гэр хороолол, зуслангийн чиглэлийн айл өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах, хүчдэлийн уналтыг сайжруулах, шугам тоноглолын хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын зураг төслийг зөвшилцөж баталгаажуулсан.	100

						Шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам, дэд станц барьж цахилгаан хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Шинэ суурьшлын бүс болон гэр хорооллын хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах, шугам дэд станц барьж, шугам сүлжээний найдвартай ажиллагааг сайжруулах 101 байршлын ажлын зураг төсвийг зөвшилцсөн. Тайлант хугацаанд цахилгаан хангамжийн 330 төсөл арга хэмжээний ажлын зураг төсөл зөвшилцсөн.	
НЗДҮАХ-ийн 6.3.31 Дулааны станц шинээр барих, өргөтгөх, технологийн шинэчлэл хийнэ.							
2.11	Налайх дүүрэг болон дэд төвүүдийн дулаан хангамжийн эх үүсвэрийн ТЭЗҮ даалгаварт санал хүргүүлэх, ажлын зураг төслийг хянан зөвшилцөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Налайх дүүргийн дулааны станцын 116МВт-ын өргөтгөл шинэчлэлтийн ажилд шаардлагатай 113.2 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2023 оны төсөвт тусгуулан шийдвэрлүүлэх саналыг боловсруулан тамгын хэлтэст хүргүүлсэн.	100
НЗДҮАХ-ийн 6.3.32. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн төв магистраль шугамуудыг өргөтгөх шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.							
2.12	6.3.32.1. Өргөтгөн шинэчлэх дулааны шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл боловсруулж, ажлын зураг төслийг хянан зөвшилцөх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Улаанбаатар хотод 2022 онд хэрэгжих дулааны шугамын өргөтгөл шинэчлэлтийн ажлын хүрээнд 1а,3в,6г, 6е, 7ж, 10б, 11в, 12в, 11г, 8б, 3г, 4а, 5а, 9г магистраль шугамын 2ф200/400/500/600/800мм-ийн 8.404км дулааны шугамын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Тус дулааны шугамын 3г, 4а, 5а магистраль 2ф400/700/1000мм голчтой 4.63км дулааны шугам нь Европын сэргээн босголтын банк, дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэхээр барилга угсралтын ажил эхэлсэн.	100
НЗДҮАХ-ийн 6.3.32. Төвлөрсөн дулаан хангамжийн системийн шугам сүлжээг шинээр барьж, нэмэгдүүлнэ.							
2.13	НЗДҮАХ-ийн 6.3.32.2. Шинээр баригдах дулааны шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл боловсруулж, ажлын зураг төслийг хянан зөвшилцөх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь.	-	100	- Улаанбаатар хотод 2022 онд хэрэгжих шинээр баригдах дулааны шугамын ажлын хүрээнд 2ф400/700/800мм-ийн голчтой 8.4хос.км шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Үүнд:	100

						<ul style="list-style-type: none"> ✓ ДЦС-4 ТӨХК-ийн 210 МВт-ын станцаас Узель-18-р цэг хүртэлх 2ф800мм голчтой 4.2 хос.кмшугамын угсратын ажил -64%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. ✓ Узель18-р цэгээс 7и магистралийн ДХ-7138-р цэг хүртэлх 1-р хорооллын арын дэнжийн зам дагуух 2ф700мм голчтой 3.2 хос.км шугамын угсралтын ажил -72%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. ✓ Узель 18-р цэгээс 1-р хорооллын араар татагдаж буй шугамнаас 3,4-р хорооллын эцэс хүртэлхи Бичил VII хороолол руу шинээр татах 2ф400мм голчтой 1.2 хос.км шугамын угсралтын ажлын санхүүжилт Европийн сэргээн босголтын санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөгдөн бэлтгэл ажил хийгдэж байна. <p>- Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар гүйцэтгэж байгаа “Залуус-1” нэгж хороолол, “Солонго-1”, “Солонго-2” нэгж хорооллын гадна дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, гадна дулаан хангамжийн ажлын зураг төсөл зөвшилцсөн.</p>	
НЗДҮАХ-ийн 6.3.33 Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна.							
2.14	6.3.33.2. Хийн түлшний дулааны эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг ЭХЯ болон холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, ТЭЗҮ боловсруулах	-	Санал	-	2	<p>2030 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нисэх Яармагийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний VIII бүс орчмын хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох 80 Гкал/цаг-ийн хий хангамжийн эх үүсвэрийн төлөвлөлтийн шийдэл боловсруулан эх үүсвэрийн техник эдийн засгийн үндэслэлд шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэхээр нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.</p> <p>4 байршилд хийн эх үүсвэр барихаар төлөвлөн ТЭЗҮ боловсруулж Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хурлаар баталсан.</p>	70

2.15	6.3.33.3. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах хийн дулааны эх үүсвэрийн зураг төслийг хянан зөвшилцөх		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	- Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ын эрчим хүчний сэргэлтийн бодлогын жагсаалтад Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах дулааны эх үүсвэр төсөл арга хэмжээ тусгагдсан. Тогтоолын хүрээнд Шархад, Зайсан, Дүнжингарав, Амгалан орчимд 4 байршилд хийн эх үүсвэр барихаар төлөвлөн ТЭЗҮ боловсруулан ЭХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн хурлаар баталсан. - Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд төлөвлөгдсөн Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачааллын горимд ажиллах Дэнжийн 1000 дэд төвийн хүрээнд 80Гкал/цаг-ийн хий хангамжийн эх үүсвэрийн техник, эдийн засгийн үндэслэл, эх үүсвэрээс тэжээгдэж буй дулаан хангамжийн ажлын зураг төсөл, би магистраль, төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосломол ажиллагаатай байхаар боловсруулсан ажлын зураг төслийг зөвшилцсөн. Хий хангамжийн эх үүсвэрийн газар чөлөөлөлтийн асуудлыг шийдвэрлүүлэхээр 2022 оны нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.	100
НЗДҮАХ-ийн 6.3.34. Мэдээлэл холбооны электрон автомат станц, мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.							
2.16	6.3.34.1. Дэд төвүүдийг хүрээнд хийгдэж байгаа мэдээлэл холбооны нэгдсэн төвийн шугам сүлжээний ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төсөл хянан зөвшилцөх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Шархад дэд төвийн мэдээлэл харилцаа холбооны ажлын зураг төсөлд санал өгч ажилласан. Яармаг, Шинэ яармаг, Буянт-Ухаа хороололд шинээр барих мэдээлэл холбооны нэгдсэн төв, худаг сувагчлалын байгууламж, шилэн кабелийн сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцсөн.	10
2.17	6.3.34.2. Шинээр хийгдэх худаг сувагчлалын байгууламжийн төлөвлөлтийн шийдэл, ажлын зургийн даалгавар боловсруулах, ажлын зураг төсөл хянан зөвшилцөх.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Шинээр хийгдэх холбоо мэдээллийн худаг, сувагчлалын 90 ажлын зураг төсөл зөвшилцсөн.	100

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД:

3.1	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, НЗД-ын 2017 оны А/335 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<p>1.Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн биелэлт;</p> <p>2.Монгол Улсын Засгийн газрын 100 хоногт Барилга, хот байгуулалтын салбарт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлт;</p> <p>3.150 мянган айлын орон сууцны хөтөлбөрийн биелэлт;</p> <p>4.Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт;</p> <p>5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт;</p> <p>6.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт;</p> <p>7.Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дулаан хангамжийн шугам сүлжээний биелэлт гаргаж ажилласан;</p> <p>8. Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний биелэлтийг нэгтгэн тайлагнасан;</p> <p>9. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд болон нийслэлийн Засаг даргын 2022 онд байгаль орчин, аялал жуулчлалын бодлогыг нийслэлд хэрэгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн тайлагнасан.</p> <p>10. Хэлтсийн сар, 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн танилцуулга материал бэлтгэн ажилласан.</p> <p>11. Засгийн газар болон Нийслэлийн үйл ажиллагааны зорилтын хүрээнд туссан 8 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>	100
-----	---	---	---------------------------------	-----	-----	---	-----

3.2	Барилга, байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд оролцож дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын зургийн дагуу барилгын ажил гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж санал өгөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хариуцсан чиг үүргийн хүрээнд холбогдох мэргэжилтэнүүд 5 байршилд барилга, байгууламжийг байнгын ашиглалтанд оруулах комиссын үйл ажиллагаанд оролцсон.	50
3.3	Хэлтсийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, жилийн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж, ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Инженерийн шугам сүлжээний ажлын зураг зөвшилцөх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд гүйцэтгэгч компанид ажлын дарааллын схем, холбогдох материал, мэдээллийг хүргүүлэн хамтран ажиллаж байна. Улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл хэмжээний үнэлгээний хороонд холбогдох мэргэжилтэнүүд оролцон ажиллаж байна.	100
3.4	Хэлтсийн албан хаагчид үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэн мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	<ul style="list-style-type: none"> • Инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөлтэй зөвшилцсөн байдал: <ul style="list-style-type: none"> ➢ Дулаан хангамж 99 ➢ Усан хангамж ариутгах татуурга 67 ➢ Цахилгаан хангамж 330 ➢ Харилцаа холбоо 90 ➢ Инженерийн н бэлтгэл арга хэмжээ 19 буюу нийт 605 Техникийн нөхцлийн хуралд оролцсон байдал: <ul style="list-style-type: none"> ➢ Төвлөрсөн усан хангамжийн сүлжээнд холбогдох 12 удаагийн ➢ Эрчим хүчний яамны дулааны эрчим хүчээр хангах 6 удаагийн, Улаанбаатар дулааны сүжлээ ТӨХК-ийн дулааны эрчим хүчээр хангах 3 удаагийн ➢ Цахилгааны эрчим хүчээр хангах Эрчим хүчний яамны 4 удаагийн хуралд, нийт 25 удаагийн хуралд оролцож, санал дүгнэлт гаргаж ажилласан. • 2022 онд улс нийслэлийн төсөв, орон нутгийн сангийн хөрөнгөөр хэрэгжих инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний ажлын зураг төсөл 	100

						<p>боловсруулах тухай хүсэлтийг холбогдох байгууллагуудаас хүлээн авч 24 асуудлыг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталж хүргүүлсэн . Үүнд</p> <ul style="list-style-type: none"> ➤ Дулаан хангамжийн шугам сүлжээ 6 ➤ Цахилгаан хангамжийн шугам сүлжээ 2 ➤ Ус хангамж ,ариутгах татуургын шугам 4 ➤ Харилцаа холбооны шугам сүлжээ 2 ➤ Инженерийн бэлтгэл арга хэмжээний чиглээр 10, нийт 24 	
3.5	3.7. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 захирамжийн хэрэгжилтийг ханган тайлагнаж ажиллах.	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	<p>1.Нийслэлийн Онцгой комиссын даргын “Сайжруулсан түлш болон дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлэх тухай” 2021 оны 15 дугаар тушаалын хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд Хан-Уул дүүргийн 9, 10 дугаар хорооноос вакцинжуулалт, түлшний мэдээ авч нэгтгэн Захиргаа,санхүүгийн хэлтэст хүргүүлж ажилласан.</p> <p>2.LRT төслийн төлөвлөлтийн трассд орсон мэдээлэл харилцаа холбооны судалгаа, төлөвлөлтийн шийдэл хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулж ажлын хэсэгт хүргүүлсэн.</p> <p>3.ХОТЫН ИРГЭНИЙ ЖИЛ” төслийн хүрээнд “ХОТЫН ИРГЭНИЙ ОРЧИН” зорилтын хүрээнд иргэний эрүүл орчинд амьдрах нөхцөлийг сайжруулах түүхийн өв соёлыг хадгалах, хамгаалах, сэргээн засварлах, менежмент хийх чиглэлээр:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Нийтийн эдэлбэрийн зам талбайг нэмэгдүүлж орц гарцыг нээх, тохижилт хийх, үерийн хамгаалалтын барилга байгууламжийг шинэчлэн сайжруулах. ➤ Түүхийн дурсгалт барилга, архитектурын өв соёлыг сэргээн засварлаж байнгын ашиглалт, арчилгаатай болгох ажлыг төлөвлөгөөнд тусгуулсан. <p>4.Ерөнхий архитекторын санаачилсан шинэ хотын төлөвлөлт “Сонсголонт төсөл”-ийн хүрээнд дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний одоогийн байдлын судалгаа болон төлөвлөлийн шийдлийг</p>	100

						<p>боловсруулж танилцуулах материал бэлтгэн ажилласан.</p> <p>5. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 22-ний өдөр болсон Улаанбаатар ус-2022 эрдэм шинжилгээний хуралд Улаанбаатар хотын ус хангамж, Инженерийн бэлтгэл арга хэмжээний одоогийн байдал төлөвлөлтийн талаар танилцуулга бэлтгэж Ерөнхий архитекторын ажлын албанд хүргүүлсэн.</p> <p>6. Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Барилга хот байгуулалтын яам, Монгол улсын шинжлэх ухаан технологийн их сургуулийн хамтран зохион байгуулсан Тогтвортой хөгжил, цэвэр орчин-2022 эрдэм шинжилгээний хуралд Улаанбаатар хотын усан хангамж, ариутгах татуурга, инженерийн бэлтгэл арга хэмжээний одоогийн байдал төлөвлөлтийн талаар танилцуулга хийж оролцсон.</p>	
3.6	3.13. Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөл болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах		Сургалта д хамрагдсан цаг /1 албан хаагч/	1 албан хаагчийн сургалтад хамрагдсан цаг /дунджаар 60 цаг/	1 албан хаагчийн сургалта д хамрагдах цаг /дунджаар 40 цагаас багагүй байх /	<p>Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан ахлах мэргэжилтнүүдэд зориулсан Улс, нийслэлийн хөгжлийн бодлогын суурь үзэл баримтлал, албан хэрэг хөтлөлт, журам, edoc системийн ашиглалтын сургалт, Газар хөдлөлт, гамшигаас хамгаалах сургалт, Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Эрчим хүчний зохицуулах хороо, Германы олон улсын хамтын нийгэмлэг GIZ-ээс хамтран зохион байгуулсан “Уур амьсгалын өөрчлөлт, Орон нутагт эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах нь” сэдэвт сургалт семинарт хэлтсийн мэргэжилтэнүүд бүрэн оролцсон.</p> <p>Төрийн албан хаагчийг чадавхижуулах Пүрэв гаригийн сургалтанд хэлтсийн мэргэжилтэнүүд тогтмол хамрагдсан.</p>	100

3.7	3.14. Архив, албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	Албан бичгийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэлтийг чанаржуулах	Шийдвэрлэлт хугацаа, хоног	10 хоног	Тайлант хугацаанд албан байгууллага, аж ахуйн нэгжээс 155 албан бичиг үрүүлсэн бөгөөд 154 албан бичгийг шийдвэрлэсэн, 1 албан бичиг судлаж байна. Албан бичиг шийдвэрлэлтийн хугацаа: 7.5 хоног	100	
		Ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг EDOC системээс хэвлэн, архивлах	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэл эр	100	2021 оны ирсэн, явуулсан бичгийн бүртгэлийг edoc системээс хэвлэн, 10 боть материалыг архивлан хүлээлгэн өгсөн.	100	
		Албан бичгийн цахим архив үүсгэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэл эр	тийм	Тайлант хугацаанд ирсэн хэлтсийн 158 албан бичиг, 40 өргөдлийг архив, албан хэрэг хөтлөлтийн холбогдох хууль журмын дагуу архивт бэлтгэн ажиллаж байна.	100	
3.8	Өргөдөл гомдлыг холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэж ажиллах	Шийдвэрлэлтэд хууль зүйн үндэслэлийг тусгаж, эцэслэн шийдвэрлэх	Шийдвэрлэлт хугацаа, хоног	9 хоног	2022 оны эхний хагас жилийн хүрээнд 40 өргөдөл гомдол ирсэн 100% шийдвэрлэн ажилласан. Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа - 9.84 хоног, 2 өргөдөлд зөрчил тооцогдсон	70	
3.9	3.16. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг батлагдсан хуваарьт хугацаанд холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөх.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	Иргэн аж ахуйн нэгжээс ирүүлсэн 2021 оны хэлтсийн үндсэн үйл ажиллагааны 417 албан бичгийн 5 боть архивын материал бэлтгэн архивт хүлээлгэн өгч цахим архив үүсгэсэн.	100	
ДӨРӨВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:							
4	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөр иргэн, хуулийн этгээдэд барилга, хот байгуулалт, дахин төлөвлөлт, газар орон зайн мэдээлэл, дэд бүтэц, барилга байгууламжийн ашиглалтын аюулгүй байдлын чиглэлээр үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, ухаалаг технологийг нэвтрүүлэн шийдвэрлэнэ.						
4.1	Инженерийн шугам сүлжээний батлагдсан трассыг хот байгуулалтын мэдээллийн нэгдсэн санд бүртгэж оруулах	-	Батлагдсан трассыг хот байгуулалтын	2021 онд 46989 м шугам сүлжээний трасс мэдээллийн	100	-Газрын даргын 2020 оны А/85 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд ХБММС дэх барилгын мэдээллийн сангийн төлөвлөгдсөн хэсгээс давхардсан, төлөвлөлт өөрчлөгдсөн, хүчингүй болсон зэрэг дэд бүтцийн төлөвлөлтийн трассыг тулгалтын ажлыг гүйцэтгэсэн. Эхний хагас	100

			мэдээллийн нэгдсэн санд оруулах	санд оруулсан		жилийн байдлаар Улс нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа 82205 метр инженерийн шугам сүлжээний трассыг хот байгуулалтын мэдээллийн санд оруулж ажилласан.
“Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх” зорилтын хүрээнд						
1	Хууль эрх зүйн мэдлэг чадварыг дээшлүүлэх болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалт, олон нийтийн арга хэмжээнд тогтмол оролцох	Байгууллагын бусад албан хаагчдын хамт сургалтад хамрагдсан байна.				1. Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлт, журам, ер, едос, өргөдөл гомдлын системийн сургалт 2. Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан ахлах мэргэжилтнүүдэд зориулсан Улс, нийслэлийн хөгжлийн бодлогын суурь үзэл баримтлал, албан хэрэг хөтлөлт, журам, едос системийн ашиглалтын сургалт 3. Нийслэлийн сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан Албан хэрэг хөтлөлт, албан бичгийн найруулга зүй сургалт 4. Төрийн албан хаагчийг чадавхижуулах Пүрэв гариг бүрийн сургалтанд нийт мэргэжилтэнүүд хамрагдаж ажилласан.

Төлөвлөгөө үнэлсэн:

Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга

Тэмдэг

.....

(гарын үсэг)

.....

(огноо)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

Захиргаа санхүүгийн хэлтсийн дарга

Тэмдэг

.....

(гарын үсэг)

.....

(огноо)

Тайлагнасан:

Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн дарга

(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч

Ц.ТУЛГА

Нэгжийн дарга

Ч.БАДАМХАНД

Нэгжийн дарга

Б.ОЮУНТУЯА

2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр